



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/567

Арвайхээр

Махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилтийн бэлтгэл болон хүн амын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор 2021 онд зах зээлд худалдан борлуулах махны хэмжээг 1 дүгээр, орон нутгийн хүн амын махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгуулах “Арвайхээр өвлийн идэш-2021” арга хэмжээнд оролцох сумдын хуваарийг 2 дугаар, нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор Улаанбаатар хотод 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулагдах махны өргөтгөсөн худалдаанд сумдаас нийлүүлэх махны хэмжээ, хуваарийг 3 дугаар, махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан хуваарь, нийлүүлэх махны хэмжээний дагуу заасан хугацаанд зохион байгуулалтын арга хэмжээ авч, мах нийлүүлэх малчид, иргэд, аж ахуйн нэгжүүдэд сурталчилж, Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн иргэдтэй мэдээлэл солилцон, борлуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх сумдын Засаг дарга нарт, өөрсдөө очиж авахаас бусад айл өрхийн хувийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн махыг нэгдсэн байдлаар орон нутгаас тээвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол шуудан ХК-ний Өвөрхангай аймаг дахь салбар (Д.Өлзийхишигт)-т тус тус үүрэг болгосугай.

3.Байгууллагын чиг үүргийн хүрээнд ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, удирдлага арга зүйгээр ханган, үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т тус тус даалгасугай.

4.“Арвайхээр өвлийн идэш-2021” арга хэмжээг сумдын удирдлагууд болон мах нийлүүлэх малчид, иргэд, аж ахуйн нэгжүүд, хэрэглэгчдэд сайтар сурталчилж, худалдааны эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг ханган, үр дүнтэй зохион байгуулахыг Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат)-д даалгасугай.

5.Махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулах, нийлүүлэлт, худалдаалалтад хяналт тавьж ажиллахыг Аймгийн засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101200

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны...
 дугаар сарын ...-ны өдрийн...
 дугаар захирамжийн нэгдүгээр
 хавсралт

СУМДААС ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛЭХ МАХНЫ ХЭМЖЭЭ
 (мян/тн)


№	Сумдын нэр	сумдаас зах зээлд нийлүүлэх махны хэмжээ /тн	Зах зээлд борлуулах мал					
			Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1	Баян-Өндөр	1189.0	46924	1795	364	8	25215	19542
2	Бүрд	1212.0	48984	1626	165	9	32139	15044
3	Бат-Өлзий	1360.0	34225	3242	2827	0	16136	12020
4	Баруунбаян-Улаан	144.0	6579	144	21	3	1685	4726
5	Баянгол	1121.0	46484	1344	190	19	27307	17624
6	Гучин-Ус	197.0	7457	346	67	23	2917	4103
7	Есөнзүйл	584.0	23905	826	59	4	13495	9520
8	Өлзийт	708.0	26521	1267	171	3	17282	7797
9	Зүүнбаян-Улаан	573.0	21847	959	184	0	13068	7636
10	Богд	217.0	10242	175	10	57	200	9800
11	Нарийнтээл	356.0	15341	470	92	2	4183	10595
12	Сант	564.0	24986	577	2	6	12153	12248
13	Тарагт	632.0	26209	921	31	3	13405	11849
14	Төгрөг	493.0	14386	468	30	217	6575	6596
15	Уянга	1113.0	35354	2018	1768	0	13355	18212
16	Хайрхандулаан	582.0	25221	794	19	7	9067	15334
17	Хужирт	873.0	29586	2266	217	0	15634	11469
18	Хархорин	1036.0	34940	2184	924	8	14324	17501
19	Арвайхээр	722.0	28242	1220	215	6	13104	13697
	ДҮН	13676.0	507434	22643	7357	377	251243	225313

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дугаар сарын 28-ны өдрийн 11/507 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АРВАЙХЭЭР СУМАНД "ИТГЭЛТ ХҮНС ТРЕЙД" МАХНЫ АГУУЛАХАД
11 ДҮГЭЭР САРЫН 25-НААС 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДРҮҮДЭД ЗОХИОН
БАЙГУУЛАГДАХ МАХНЫ ХУДАЛДААНЫ ХУВААРЬ

№	Сумдын нэр	Арвайхээр суманд зохион байгуулагдах худалдаанд мах борлуулах хугацаа	Тайлбар
1	Баруунбаян-Улаан	11.25 - 11.28	1. Амьд мал болон мах борлуулна. 2. Мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээтэй байна. 3. Мал, мах борлуулагч нь эрүүл ахуй, халдвар хамгааллын хувийн бэлтгэлээ сайтар хангаж ирнэ. (хөдөлмөр хамгаалын хувцас, хормогч, халад, бээлий, гар ариутгагч, сав баглаа боодол гэх мэт) 4. Дэлгэрэнгүй мэдээллийг Арвайхээр сумын ХААТасгийн мэргэжилтэн (Д.Энхтуяа, Д.Цэдэнхүү, Ц.Эрдэнэжаргал утас 95321666, 99573338, 88004933) Арвайхээр сумын Мал эмнэлэгийн тасгийн малын эмч Ё.Гэрэлт-Од 99840255 утсаар тус тус холбогдож лавлана .
2	Баянгол	11.25 - 11.28	
3	Богд	11.25 -11.28	
4	Гучин-ус	11.25 -11.28	
5	Зүүнбаян-Улаан	11.25 -11.28	
6	Нарийнтээл	11.25 -11.28	
7	Тарагт	11.25 -11.28	
8	Төгрөг	11.25 -11.28	
9	Уянга	11.25 -11.28	
10	Хайрхандулаан	11.25 -11.28	
11	Арвайхээр	11.25 -11.28	

Аймгийн Засаг даргын 2021 оны...¹¹
 дугаар сарын...²²...-ны өдрийн...^{11/567}
 дугаар захирамжийн гуравдугаар
 хавсралт



УЛААНБААТАР ХОТОД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ МАХНЫ
 ӨРГӨТГӨСӨН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХУВААРЬ

№	Сумдын нэр	УБ хотод мах борлуулах хугацаа	Төв Цэнгэлдэх хүрээлэн		Тайлбар
			хоногт нийлүүлэх мах /тн/	бүгд /тн/	
1	Баян-Өндөр	11.25-12.02	3.5	28.0	УБ хотын "Хархорин", "Фүүд сити", "Саппоро", "Алтжин бөмбөгөр" худалдааны төвүүдэд 2021 оны 12-р сарын 03-ны өдрөөс 12-р сарын 20-ний өдрүүдэд махны өргөтгөсөн худалдаа үргэлжлэх тул дээрх хугацаанд тус худалдааны төвүүдэд мах борлуулах хүсэлтэй сумдууд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн С. Бат-эрдэнэ 99327090, Г. Дэлгэрмаа 88524958 утсаар тус тус холбогдож лавлана .
2	Бүрд	11.25-12.02	3.5	28.0	
3	Бат-Өлзий	11.25-12.02	3.5	28.0	
4	Уянга	11.25-12.02	3.0	24.0	
5	Есөнзүйл	11.25-12.02	2.5	20.0	
6	Өлзийт	11.25-12.02	2.5	20.0	
7	Сант	11.25-12.02	2.5	20.0	
8	Баянгол	11.25-12.02	2.5	20.0	
9	Хархорин	11.25-12.02	3.5	28.0	
10	Хужирт	11.25-12.02	3.5	20.0	
11	Арвайхээр	11.29-12.02	3.0	24.0	
	ДҮН	11.25-12.02	33.5	260.0	

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн 41/567 дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

**“ӨВЛИЙН ИДЭШ” МАХНЫ ӨРГӨТГӨСӨН ХУДАЛДАА
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	Тухайн арга хэмжээг эхлүүлэх үеийн бэлтгэл ажлыг бүрэн хангах,	2021.11.17 2021.11.24	Сумын Засаг дарга нар
2	Арга хэмжээний төлөвлөгөө гаргаж батлуулах	2021.11.18	Хүнс, хөдөө аж ахуйн газар
3	Малчдаас нийлүүлж буй малын махыг мал эмнэлгийн үйлчилгээнд бүрэн хамруулж, гарал үүслийн гэрчилгээнд худалдаалах байршлыг тусган бичих	2021.11.25 2021.12.19	Мал эмнэлгийн газар
4	Мал эмнэлгийн нэгдсэн системийн гарал үүслийн гэрчилгээний бичилтэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд мах болон түүхий эдээс шинжилгээний дээж авч лабораторид хүргүүлэх	2021.11.25 2021.12.20	Мал эмнэлгийн газар
5	Тухайн арга хэмжээ зохион байгуулагдаж дуусах хүртэлх хугацаанд хуваарийн дагуу тасралтгүй нийлүүлэх	2021.11.25 2021.12.20	Сумын Засаг дарга нар
6	Оролцох иргэн, аж ахуйн нэгжийг худалдааны үеийн бэлтгэл ажлыг хангуулах (баталгаажсан жин, хормогч, малгай, бээлий, гар ариутгагч, дархлаажуулалтын талаарх баримт гэх мэт)	2021.11.25 2021.12.20	Сумын Засаг дарга нар
7	Мах худалдаалах үед хэрэглэгдэх сав, баглаа боодлыг бэлтгүүлэх	2021.11.25 2021.12.20	Сумын Засаг дарга нар
8	Махны өргөтгөсөн худалдааны үеэр эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж ажиллах	2021.11.25 2021.12.20	Худалдан борлуулагчид
9	Борлуулалтын мэдээг өдөр бүр нэгтгэж, мэдээлэх	2021.11.25 2021.12.20	Сумдын Мал эмнэлэгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг
10	Мэдээ судалгааг нэгтгэж, ХХААХҮЯам болон орон нутгийн удирдлагуудад мэдээллэх, тайлагнах	2021.11.25 2021.12.20	Хүнс, хөдөө аж ахуйн газар